



ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,
ГЕОДЕЗИ ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 03 сарын 22 өдөр

Дугаар

А/08

Улаанбаатар хот

Нэрэмжит жил батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын дэргэдэх зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн хуралдааны 01 дүгээр тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Газрын харилцааны салбарын хэмжээнд ажиллаж байгаа албан хаагчдыг чадавхжуулах зорилгоор 2022 оныг “Хүний нөөцийн хөгжлийг дэмжих” жил болгон баталсугай.

2. Нэрэмжит жилийн хүрээнд 2022 оны сургалт хөгжлийн төлөвлөгөө болон олон нийтэд хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан мэдээллэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллахыг Захиргаа, удирдлага, хамтын ажиллагааны газар /Р.Ганхуяг/-т, ажиллах орчин нөхцөл, шаардлагатай тоног төхөөрөмжийн судалгааг гарган санхүүжилтийг шийдвэрлэх, төсөвт тусгуулах ажлыг зохион байгуулахыг Санхүү, эдийн засгийн хэлтэс /Л.Лувсан/-т тус тус даалгасугай.

3. “Хүний нөөцийн хөгжлийг дэмжих” жилийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангаж, ажлын явц, үр дүнг танилцуулахыг Орлогч дарга /М.Буяндэлгэр/-д, олон нийтэд мэдээллэх, сурталчлан ажиллахыг Захиргаа, удирдлага, хамтын ажиллагааны газар /Р.Ганхуяг/-т тус тус даалгасугай.

ДАРГА



А. ЭНХМАНЛАЙ

1502010179